

ЧЕХ УЛС ДАХЬ СУРТГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ

Сургуулийн өмнөх боловсролын зорилтууд

Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын төгсгөлд өвөрмөц бөгөөд харьцангуй бие даасан хувь хүн болгож, өөрт нь тавигдсан, түүнийг ирээдүйд хүлээж буй амьдралын эрэлт хэрэгцээг идэвхтэй, сэтгэл ханамжтайгаар удирдаж чаддаг хүн болгоход зориулсан юм.

Чех улсын сургуулийн өмнөх боловсролын зорилгод дараахь зүйлс орно:

- гэр бүлийн боловсролыг нэмэж хөгжүүлэх ба дэмжих;
- хүүхдийн хувь хүний шинж чанарыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- хүүхдийн сэтгэл хөдлөл, оюун санаа ба бие бялдын эрүүл хөгжлийг дэмжих;
- хүүхдэд орчин тойрон ертөнцийг ойлгоход нь туслах, цаашдын мэдлэг ба сурах сэдлийг төрүүлэх;
- ёс суртахууны үндсэн дүрмүүд, амьдралын үнэ цэнэ ба хүмүүс хоорондын харилцааг ойлгох ба эзэмших боломжийг олгох;
- суурь боловсрол эзэмшихээс өмнөх хүүхдийн тэгш бус хөгжлийг тэнцвэржүүлэх;
- боловсрол үргэлжлүүлэхэд урьдчилсан нөхцлийг бүрдүүлэх;
- боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд сурган хүмүүжүүлэх тусгай тусламж үзүүлэх.

Сургуулийн өмнөх боловсролын онцлог

- Сургуулийн өмнөх боловсролын ажлын арга ба хэлбэрийг хүүхдийн хэрэгцээнд тохируулан боловсруулдаг.
- Сургуулийн өмнөх боловсрол нь хүүхдүүдэд сэтгэл ханамжтай ба урам зоригтой байх, тохь тухтай орчныг хангадаг, тэдэнд байгалиас заяасан хүүхэд шиг байдлаар илэрхийлэх ба хөгжих боломжийг хадгалдаг.
- Хүүхэд болгоны хувь хүний хэрэгцээ ба боломжийг хүндэтгэдэг.
- Боловсрол нь гол төлөв туршилтаар суралцах ба тоглоомоор суралцах замаар явагддаг. Эдгээр аргууд нь хүүхдийн сониуч зан авир ба шинэ юм нээж мэдэх хэрэгцээг дэмжих зорилготой юм.

Боловсролын агуулга нь боловсролын 5 чиглэлд тулгуурлана.

1. **Хүүхэд ба түүний бие махбодь** – бодит бие бялдрын хөгжил ба хөдөлгөөний зохицуулалт, хөдөлгүүрийн нарийн ур чадвар, гар ба нүдний зохицуулалт, өөрийгөө арчлах, эрүүл мэнд, аюулгүй байдал.

2. **Хүүхэд ба түүний сэтгэл зүй**

о Хэл ба яриа - дуудлага, ярианы дүрмийн зөв байдал, ойлголт, харилцаа холбоо, илэрхийлэл.

о Танин мэдэхүйн чадвар ба үйл ажиллагаа, төсөөлөл, уран зөгнөл, бодлын үйл ажиллагаа - ойлголт, анхаарал, төвлөрөл, ой санамж, бүтээлч байдал, овсгоо самбаа, уран сэтгэмж, дүрслэх ба график тэмдгийг ялгах, график илэрхийлэл, орон зайн чиг хандлага, математикийн өмнөх үндсэн ойлголтууд, тоо ба тооны ойлголтууд ба үйл ажиллагаа, асуудал шийдвэрлэх, сурах.

о Өөрийгөө ойлгох, мэдрэхүй, хүсэл зориг - өөртөө итгэх итгэл, бие бялдрын дасгал, өөрийгөө хянах чадвар, дасан зохицох чадвар, өөрийн үзэл баримтлал, мэдрэмж, хүсэл зориг.

3. **Хүүхэд ба бусад нь** - насанд хүрэгчидтэй харилцах, хүүхдүүдтэй харилцах, үйл ажиллагааны үед хамтын ажиллагаа, нийтэч байдал.

4. **Хүүхэд ба нийгэм** - нийгмийн дүрэм журам ба дадал зуршил, нийгэм, соёл, урлагт хамрагдах.

5. **Хүүхэд ба ертөнц** - мэдлэг, нийгмийн ухамсар, өөрчлөлтөнд дасан зохицох чадвар, хүрээлэн буй орчин тойронтой харьцах харилцаа.

Сургуулийн өмнөх боловсролын зохион байгууллага

- Хичээлийн жил 9-р сарын 1-нд эхлэж, дараа жилийн хуанлийн 8-р сарын 31-нд дуусна.

- Сургуулийн өмнөх боловсролыг 2-оос 6 хүртэл насны хүүхдүүдэд зохион байгуулдаг (хоёр настай хүүхэд цэцэрлэгт орох хууль ёсны шаардлагагүй).

- Дараагийн хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд орох элсэлт нь 5-р сарын 2-оос 5-р сарын 16-нд хүртэл явагдана.

- Сургуулийн өмнөх боловсролын үүрэг нь хичээлийн жилийн эхэн үеэс эхлэн хүүхэд нь 5 нас хүрэх өдөр хүртэл тавиггдаг.

- Сургуулийн өмнөх боловсрол нь Европын Холбооны бусад гишүүн улсын иргэд, Чех улсад 90 хоногоос дээш хугацаагаар оршин сууж байгаа, түүнчлэн Чех улсад байнга буюу түр хугацаагаар 90 хоногоос илүү хугацаагаар оршин суух эрхтэй бусад гадаадын иргэдэд, олон улсын хамгаалалт олгох тухай үйл ажиллагаанд оролцогчдод ч гэсэн хамаардаг. Сургуулийн өмнөх боловсрол нь сэтгэцийн гүнзгий хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хамаарахгүй.

- Сургуулийн өмнөх боловсролын заавал оролцох жилийн хугацааг бусад аргаар ч гэсэн хэрэгжүүлж болно. Үүнд хувь хүний боловсрол, бага сургуулийн бэлтгэл ангийн боловсрол, тусгай бага сургуулийн бэлтгэл үе шатны боловсрол, Чех Улс дахь гадаад сургуулийн боловсролд оролцож болно.

- Сургуулийн захирал нь сургуулийн зөвлөгөө өгөх байгууллагын зөвлөмжийг үндэслэж, боловсролын тусгай хэрэгцээтэй эсвэл ер бусын боловсролын авъяас билигтэй хүүхдийг

ганцаарчилсан боловсролын хөтөлбөрийн дагуу зохицуулан сургаж болно. Хөтөлбөр нь бэрхшээлтэй салбарт хүүхдийг дэмжих боломж ба арга замыг тодорхойлдог.

- Боловсролын хүрээний хөтөлбөр нь боловсролын заавал биелүүлэх хэрэгтэй агуулга, хамрах хүрээ ба боловсролын нөхцлийг тодорхойлдог, энэ нь сургуулийн өмнөх боловсролд заавал мөрдөгдөх ёстой. Боловсролын хүрээний хөтөлбөр нь сургуулийн боловсролын хөтөлбөрийг зохион байгуулахад заавал байх ёстой.

Хүүхдийн цэцэрлэг

- Чех улсад хүүхдүүд нь улсын болон хувийн цэцэрлэгт хамрагдах боломжтой.

- Аав ээж нь хүүхдийн цэцэрлэгт хүүхдийн сургалтын төлбөрийг сургалтын төлбөр гэж нэртэй төлбөрөөр төлдөг. Цаашид нь бас хүүхдийн хоолны мөнгийг төлдөг. Тийм учраас хүүхдийг цэцэрлэгт бүтэн өдрийн хоолоор ба түүний дотор уух ундаагаар хангаж өгдөг. Улс, бүс нутаг, хотын захиргаа эсвэл хотын захиргааны байгууллагуудын холбооноос байгуулсан цэцэрлэгт сүүлийн жилд сургалтын төлбөрийг дээд тал нь 12 сарын түршид төлдөггүй, гэвч тэнд

(хоолны мөнгө) төлдөг.

- Улсын цэцэрлэгт нэг ангийн хүүхдүүдийн тоо хамгийн ихдээ 28 хүүхэд байж болно, тэдэнтэй ихэвчлэн 2 багш ажилладаг. Нэмж дурдахад ангид бас заах багшийн туслах ажилтан, хоёр хэлээр заах багшийн туслах ажилтан эсвэл асрагч байж болно.

- Хүүхдүүдийг ижил насаар эсвэл нас харгалзахгүйгээр анги болгон хувааж болно.

- Хүүхдүүд цэцэрлэгээс гэртээ очихдоо үдийн цайны дараа эсвэл үдээс хойш амрасны дараа том хүнийг дагаж хамт явдаг.

- Хүүхэд цэцэрлэгт байхгүй байх тохиолдолд тухайн цэцэрлэгийн сургуулийн дүрмийн дагуу уучлалт бичиж буюу хэлж мэдүүлэх ёстой.

- Цэцэрлэг болгонд өдрийн дэглэм нь өөр өөр байж болох бөгөөд хүүхдүүд ирэх ба цуглуулах цагийг заавал дагаж мөрдөх шаардлагатай. Шаардлагатай тохиолдолд эцэг эх нь цэцэрлэгийн удирдлага ба багш нартай нь тус тусдаа хэлэлцэж тохиролцдог.

- Өдрийн дэглэмийн жишээ:

о хүүхдүүдтэй уулзах, чөлөөт цагийн тоглоом тоглох, хүүхдүүдтэй ганцаарчилсан ажил хийх;

о олон нийтийн дугуйлан - сэдэвчилсэн яриа, шүлэг хэлэх, дуу дуулах, оньсого таавар хэлэх;

о эрүүл мэндийн дасгалууд - хөдөлгөөнт тоглоомууд, амьдрах орчинд хийх дасгалууд, эрүүл мэндийн дасгалууд, амралт;

о зууш;

о сонгосон сэдвээр боловсролын үйл ажиллагаа - урлаг, хөгжим, хөдөлгөөн, ажил, оюун ухаан;

о цэцэрлэгийн гаднах цэцэрлэгт зугаалах эсвэл гадуур алхах;

о үдийн хоол ;

о үдийн завсарлагааны амралт;

о зууш;

о чөлөөт цагийн тоглоом, хүүхдүүдийн явах тухай.

- Боловсрол нь нэгдсэн блокууд дээр суурилж явуулагддаг, хүүхдүүдэд сонгосон сэдвүүдийн агуулгыг харилцан холбоотойгоор нь зааж өгдөг. Хүүхдийн хувьд олж авсан туршлага нь амархан ойлгогдох бөгөөд практик байдлаар ашиглах боломжт ой. Хэлэлцсэн сэдвүүд нь тухайн цэцэрлэгийн сургуулийн боловсролын хөтөлбөрт үндэслэсэн байдаг.

- Хүүхдэд зориулсан үйл ажиллагааг аяндаа эсвэл хяналттай гэж хувааж болно. Тиймээс зарим үйл ажиллагааг хүүхдүүд өөрсдөө удирдадаг ба зарим үйдлийг багш нь шууд болон дам байдлаар нөлөөлдөг.

Хүүхдийн цэцэрлэгийн багш

- Цэцэрлэгийн багш нь цэцэрлэгийн багшийн мэргэжлийн чадвартай байх ёстой, цэцэрлэгийн багш болох бэлтгэлд сургалтанд анхаарч, мэргэжлээрээ сурч, үр чадвартай болох шаардлагатай.

- Багш нар сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны явцад нэмэлт боловсрол эзэмшүүлэх үүрэгтэй бөгөөд үүгээр мэдлэг чадвараа шинэчлэх, хадгалах ба ялангуяа дээшлүүлэх хэрэгтэй.

- Багшийн даалгавар бол зохих үйл ажиллагааг эхлүүлэх, хүрээлэн буй орчин тойрныг бэлтгэх, хүүхдүүдэд өөрсдийгөө болон эргэн тойронд бодит байдлыг таньж мэдэх, бодох ба ойлгох боломжийг олгох явдал юм.

- Багшийн ажил нь хүүхэд бүрийн хувь хүний хэрэгцээ ба ашиг сонирхлыг ажиглах, ухамсарлах замаар тодорхойлох, сурган хүмүүжүүлэх оношлогоонд үндэслэдэг бөгөөд хүүхдийн өнөөгийн байдлын ба хөгжлийн талаархи мэдлэг, түүний ахиц дэвшилд тогтмол хяналт тавьж байж ажилласнаас үр дүн нь гарч ирдэг юм.

Бэлтгэсэн: Бакалавр Кристына Зимкова, Хүүхдийн цэцэрлэг, Матехова, Прага 4

Эх сурвалж

Чех улсын Боловсрол, залуучууд ба спортын яам. *Сургуулийн өмнөх боловсролд зориулсан боловсролын хүрээний хөтөлбөр* [онлайн]. Прага: Боловсролын , залуучууд ба спортын яам, 2018 [иш татсан 2020.05.11]. <http://www.msmt.cz/file/45303/> хаягаас авах боломжтой.

Хуулийн эмхтгэлийн 561/2004 тоот хууль (Сургуулийн тухай хууль), Сургуулийн өмнөх, бага, дунд, дээд мэргэжлийн болон бусад боловсролын тухай.